



LEGAL NEWSLETTER

2026.08.11

№68

AKP Law Firm

Бид 2026 оны 08 дугаар сарын 11-ний өдрийг хүртэлх батлагдсан онцлох хууль, тогтоол, шийдвэрүүдийг танилцуулж байна.

I. ХУУЛЬ ТОГТООМЖ:

1.1 Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Газрын тосны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “хуваалтыг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулах ба энэ хуулийн 17.3.2-т заасан нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтооно.” гэснийг “хуваалт болон татвар, шимтгэлийг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулна” гэж өөрчилсөн байна.

Уг нэмэлт өөрчлөлт нь Газрын тосны тухай 1991 оны хуулийн хүрээнд байгуулагдсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцөлийг тогтвортой хадгалах, тухайн гэрээнд заасан татвар, шимтгэл, нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтыг олон улсын гэрээтэй адилтган гэрээний дагуу хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхой болгох зорилготой байна.

Мөн уг нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын тухай хууль болон Татварын ерөнхий хуульд тус тус өөрчлөлт оруулж, 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Газрын тосны тухай хуулийн хүрээнд байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд зааснаар нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөхөөс гадна татвар, актын төлбөрийг тухайн жилийн төсвийн тухай хуульд тусган бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан Монгол Улсын Засгийн газарт ногдох газрын тосны төлбөрт суутган тооцохоор болсон байна.

1.2 Цусны донорын тухай

УИХ-ын 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан

Цусны донорын тухай хууль нь хуулийн зорилго, хуульд тодорхойлогдох шаардлагатай нэр томъёоны тодорхойлолт, зарчим, үйл ажиллагааг зохион байгуулах удирдлагын тогтолцоо, Монгол Улсын Засгийн газар болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн байгууллагын бүрэн эрх, цус сэлбэлт судлалын харилцаанд оролцогч төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын албан тушаалтан, эрүүл мэндийн байгууллагын эрх, үүрэг, санхүүжилтийн тогтолцоо, цусны донор, сэлбүүлэгч, эрүүл мэндийн байгууллага, ажилтанд тавигдах шаардлага, цусны донороос цус, түүний бүрэлдэхүүн хэсгийг эмчилгээний зориулалтаар авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, сэлбэх, устгах үйл ажиллагааны зохицуулалт, цусны донорын мэдээллийн сан, цусны донорын эгнээг өргөжүүлэхтэй холбоотой сургалт, сурталчилгаа, алдаршуулалт, урамшуулалт, нийгмийн халамж, хариуцлагын хэсгийг тусгасан нийт 8 бүлэг, 35 зүйлтэй байна.

1.3 Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуульд хуулийн ерөнхий зарчим, нийтлэг үндэслэл, реципиент болон амьд донорт тавих шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг, амьгүй донорыг илрүүлэх, бүртгэх, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээ, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны үйл ажиллагааны удирдлага, бүтэц, зохион байгуулалт зэрэг үйл ажиллагааны зохицуулалтуудыг тусгасан нийт 5 бүлэг 25 зүйлтэй байна.

1.4 Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай

УИХ-ын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн 1.3.1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн давж заалдах шатны шүүх, 2.4.1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийг тус тус байгуулахаар болсон.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдсанаар Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх байгуулагдсантай холбогдуулан Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгжид хамаарах нэхэмжлэл, хүсэлтийг Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны тойргийн шүүх харьяалан анхан шатны журмаар хянан шийдвэрлэх ба уг хууль нь 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр байна.

II. УЛСЫН ИХ ХУРАЛ: ОНЦЛОХ ТОГТООЛ

2.1 Засгийн газарт чиглэл өгөх тухай

УИХ-ын тогтоолуудаар “Малчны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх” сэдэвт ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулсантай холбогдуулан 11 арга хэмжээг, Орон сууц захиалах, худалдан авах асуудлыг зохицуулж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох, энэ хүрээнд үүсэж байгаа зөрчил, маргааныг шийдвэрлэх, хохирсон иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор 7 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт тус тус даалгасан байна.

2.2 Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

- i. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийг баталсантай холбогдуулан Зөрчлийн тухай хууль болон холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулах, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд оролцож байгаа эрүүл мэндийн байгууллага болон холбогдох бусад байгууллагын албан хаагч, ажилтан, иргэн, хуулийн этгээдэд хуулийг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагыг байгуулах, байгууллагыг байгуулах хүртэлх хугацаанд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албанд хариуцуулах, хуульд нийцүүлэн Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам батлах болон бусад холбогдох журмыг шинэчлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан байна.

- ii. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баталсантай холбогдуулан шүүхийн барилга байгууламж шинээр барих байршил, газрын асуудлыг судалж, шийдвэрлэх, зориулалтын шүүх хуралдааны танхим, хүүхдээс мэдүүлэг авах тусгай өрөө байгуулах асуудлыг судалж, зардлыг төсөвт тусгуулах, хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаан дахь эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйч, мэргэжилтнийг бэлтгэх, гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах, шүүхийн цахим үйлчилгээний үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хэрэг, маргааныг шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт тусгуулах, эвлэрүүлэн зуучлах багийн сэтгэл зүйчийн ажиллах журмыг батлах болон бусад холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт тус тус даалгасан байна.

III. ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦЛОХ ТОГТООЛ

3.1 Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 252 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Хөгжлийн банкны дүрэм”-ийн 4.1 дэх хэсгийг “Банкны зарласан болон гаргасан хувьцаа нь нийт 20,000,000 (хорин сая) ширхэг бөгөөд нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 15,000,000 (арван таван сая) ширхэг энгийн, 5,000,000 (таван сая) ширхэг давуу эрхийн хувьцаанд хуваагдана. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 2,000,000,000,000 (хоёр их наяд) төгрөг байна.” гэж өөрчилсөн байна.

Мөн дүрмийн 4.2 дахь хэсэгт “Давуу эрхийн хувьцаа нь тодорхой хугацаагүй, ногдол ашиг тогтмол төлөх үүрэггүй, ногдол ашгаас бусад хэлбэрээр өгөөжийн бүтэцгүй, энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлгүй, эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасан асуудлыг хэлэлцэхэд нэг ширхэг давуу эрхийн хувьцаа нэг саналын эрхтэйгээр оролцох бөгөөд үүнээс бусад асуудлыг хэлэлцэхэд саналын эрх эдлэхгүй болно.” гэж нэмэлт оруулсан байна.

Тус дүрмээр Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гаргах гэрээ, хэлцлийн үнийн дүнг өөрийн хөрөнгийн 0.6 хувь байсныг 25 хувь болгон өөрчилсөн байна.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Олимпийн гудамж, Centrum Office, 3
давхар, 301/a
Web: www.akp.mn
E-mail: contact@akp.mn
Tel: 7704-1414, 8013-0414